

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Гурван-Эрдэнэ ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/163/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99389927 Цахим хаяг:
mandakhnaranl@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
Товчилсон үгийн жагсаалт	Error! Bookmark not defined.
УСНББОУС.....	Error! Bookmark not defined.
Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт	Error! Bookmark not defined.
АДБОУС.....	Error! Bookmark not defined.
Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт	Error! Bookmark not defined.
Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг	Error! Bookmark not defined.
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
4.3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/210
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ГУРВАН-ЭРДЭНЭ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
П.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Хараат бус аудитын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Гурван-Эрдэнэ сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс санхүүжих дүнгээс 37,382.3 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт олгосонтой холбоотойгоор тогтмол зардлын 63,099.9 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар цалин олголттой холбоотой 2,817.8 мянган төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 594.0 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно.

Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын ерөнхий боловсролын Гурван-Эрдэнэ сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 33 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 86.9 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	484,945,463.90	209,746,069.19
МӨНГӨН ХӨРӨНГӨ		
Банкинд байгаа бэлэн мөнгө	336,255,824.35	33,630,571.78
Төгрөг	336,255,824.35	33,630,571.78
Төрийн сангийн харилцах	336,255,824.35	33,630,571.78
БАРАА МАТЕРИАЛ	148,689,639.55	176,115,497.41
Түүхий эд материал	1,573,050.00	2,943,250.00
Эм боох материал	1,573,050.00	2,943,250.00
Хангамжийн материал	147,116,589.55	173,172,247.41
Бичиг хэргийн материал	909,470.00	92,000.00
Аж ахуйн материал	29,731,015.00	36,110,880.00
Барилгын засварын материал	321,000.00	00.00
Хүнсний материал	153,540.00	11,803,685.00
Бусад хангамжийн материал	116,001,564.55	125,165,682.41
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,889,696,488.39	2,742,070,627.51
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,889,696,488.39	2,742,070,627.51
Биет хөрөнгө	2,723,485,105.76	2,578,183,613.25
Барилга, байгууламж, орон сууц	2,427,212,904.37	2,427,212,904.37
Хуримтлагдсан элэгдэл	-526,065,423.02	-613,354,797.74
Машин тоног төхөөрөмж (компьютер)	741,231,275.60	778,548,146.39
Хуримтлагдсан элэгдэл	-279,730,558.98	-349,868,184.30
Тавилга, аж ахуйн эд хогшил	117,428,386.07	138,131,432.07
Хуримтлагдсан элэгдэл	-62,414,309.73	-71,669,553.39
Бусад үндсэн хөрөнгө	387,341,867.00	392,286,867.00
Хуримтлагдсан элэгдэл	-147,062,515.39	-178,938,114.99
Ном	65,543,479.84	55,834,913.84
Биет бус хөрөнгө	166,211,382.63	163,887,014.26
Програм хангамж	9,775,056.50	7,044,056.50
Хуримтлагдсан элэгдэл	-5,801,673.87	-5,395,042.24
Бусад биет бус хөрөнгө	162,238,000.00	162,238,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,374,641,952.29	2,951,816,696.70
НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	63,099,900.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	63,099,900.00
Өглөг	00.00	63,099,900.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	63,099,900.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,374,641,952.29	2,888,716,796.70
Засгийн газрын хувь оролцоо	3,374,641,952.29	2,888,716,796.70
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,442,051,483.77	1,442,051,483.77
Өмч: - төрийн	1,442,051,483.77	1,442,051,483.77
Хуримтлагдсан үр дүн	384,318,652.04	-101,606,503.55
Өмнөх үеийн үр дүн	384,318,652.04	384,318,652.04
Тайлант үеийн үр дүн	00.00	-485,925,155.59
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,548,271,816.48	1,548,271,816.48
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,374,641,952.29	2,951,816,696.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,926,364,354.00	4,130,208,360.50
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	131,874,254.00	90,210,060.50
Нийтлэг татварын бус орлого	131,874,254.00	90,210,060.50
Төсөв байгууллагын өөрийн орлого	113,742,453.10	60,428,886.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,139,700.00	15,975,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	00.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	111,392,753.10	44,453,886.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,131,800.90	29,781,174.50
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,794,490,100.00	4,039,998,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	3,569,590,100.00	3,817,248,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,569,590,100.00	3,817,248,300.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	224,900,000.00	222,750,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	224,900,000.00	222,750,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,945,248,200.55	4,599,883,914.09
УРСГАЛ ЗАРДАЛ	3,945,248,200.55	4,599,883,914.09
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,753,704,108.03	4,341,535,979.09
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,743,673,397.17	3,188,898,933.93
Үндсэн цалин	1,784,281,887.17	2,037,867,149.00
Нэмэгдэл	808,398,355.00	902,186,650.93
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	100,889,004.00
Урамшуулал	150,993,155.00	147,956,130.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	346,001,013.19	395,792,379.43
Тэтгэврийн даатгал	236,299,495.93	269,891,258.28
Тэтгэмжийн даатгал	27,717,931.46	31,750,962.94
ҮОМШӨ-ний даатгал	14,010,365.41	15,942,151.00
Ажилгүйдлийн даатгал	13,614,995.09	15,780,229.55
Эрүүл мэндийн даатгал	54,358,225.30	62,427,777.66
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,821,692.00	275,849,900.00
Гэрэл, цахилгаан	11,935,839.00	20,000,000.00
Түлш, халаалт	177,907,515.00	235,849,900.00
Цэвэр, бохир ус	9,978,338.00	20,000,000.00
Хангамж, бараа материалын зардал	32,639,384.27	30,217,911.64
Бараа материал акталсны зардал	32,639,384.27	30,217,911.64
Эд хогшил, урсгал засварын зардал	44,005,475.48	8,277,000.00
Урсгал засвар	44,005,475.48	8,277,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,939,994.11	82,499,078.21
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,138,900.00	15,975,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,801,094.11	66,524,078.21
Бараа үйлчилгээний бусад зардал	350,623,151.81	360,000,775.88
Бараа үйлчилгээний бусад зардал	69,700,813.00	67,923,081.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,403,745.00	15,201,400.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	257,518,593.81	276,876,294.88
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	191,544,092.52	258,347,935.00

Бусад урсгал шилжүүлэг	187,813,360.00	258,347,935.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	170,039,960.00	242,330,035.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,773,400.00	16,017,900.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,730,732.52	00.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-18,883,846.55	-469,675,553.59
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,345,799.00	16,249,602.00
Үнэ төлбөргүй гарсан зардал	8,345,799.00	16,249,602.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-8,345,799.00	-16,249,602.00
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-27,229,645.55	-485,925,155.59

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн /төгрөгөөр/
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,285,913,483.77	19,154,931.60	-60,651,449.92	1,244,416,965.45
Тайлант үеийн үр дүн	156,138,000.00	00.00	-35,950,880.99	120,187,119.01
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,442,051,483.77	1,548,271,816.48	384,318,652.04	3,374,641,952.29
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-485,925,155.59	-485,925,155.59
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,442,051,483.77	1,548,271,816.48	-101,606,503.55	2,888,716,796.70

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,796,839,800.00	4,055,973,300.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,349,700.00	15,975,000.00
Нийтлэг татварын бус орлого	2,349,700.00	15,975,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,349,700.00	15,975,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,139,700.00	15,975,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	00.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,794,490,100.00	4,039,998,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	3,569,590,100.00	3,817,248,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,569,590,100.00	3,817,248,300.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	224,900,000.00	222,750,000.00

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	224,900,000.00	222,750,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,668,930,932.47</u>	<u>4,257,552,402.57</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	<u>3,668,930,932.47</u>	<u>4,257,552,402.57</u>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>3,475,602,399.95</u>	<u>3,987,554,322.57</u>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,743,673,397.17	3,188,898,933.93
Үндсэн цалин	1,784,281,887.17	2,037,867,149.00
Нэмэгдэл	808,398,355.00	902,186,650.93
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	100,889,004.00
Урамшуулал	150,993,155.00	147,956,130.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	346,001,013.19	395,792,379.43
Тэтгэврийн даатгал	236,299,495.93	269,891,258.28
Тэтгэмжийн даатгал	27,717,931.46	31,750,962.94
ҮОМШӨ-ний даатгал	14,010,365.41	15,942,151.00
Ажилгүйдлийн даатгал	13,614,995.09	15,780,229.55
Эрүүл мэндийн даатгал	54,358,225.30	62,427,777.66
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,821,692.00	212,750,000.00
Гэрэл, цахилгаан	11,935,839.00	20,000,000.00
Түлш, халаалт	177,907,515.00	172,750,000.00
Цэвэр, бохир ус	9,978,338.00	20,000,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	21,347,575.48	10,000,000.00
Урсгал засвар	21,347,575.48	10,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,939,994.11	83,810,578.21
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,138,900.00	15,975,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,801,094.11	67,835,578.21
Бараа үйлчилгээний бусад зардал	127,818,728.00	96,302,431.00
Бараа үйлчилгээний бусад зардал	98,723,778.00	75,413,531.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,094,950.00	20,888,900.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>193,328,532.52</u>	<u>269,998,080.00</u>
Бусад урсгал шилжүүлэг	189,597,800.00	269,998,080.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	171,824,400.00	253,980,180.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,773,400.00	16,017,900.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,730,732.52	00.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,730,732.52	00.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>127,908,867.53</u>	<u>-201,579,102.57</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>85,419,000.00</u>	<u>101,046,150.00</u>
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>85,419,000.00</u>	<u>101,046,150.00</u>
Дотоод эх үүсвэрээр	85,419,000.00	101,046,150.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,419,000.00	101,046,150.00

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-85,419,000.00</u>	<u>-101,046,150.00</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	42,489,867.53	-302,625,252.57
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	293,765,956.82	336,255,824.35
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	336,255,824.35	33,630,571.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<u>Татаас, санхүүжилтийн орлого</u>	4,399,381,200.00	4,055,973,300.00	343,407,900.00	92.19%
Улсын төсвөөс	3,824,308,400.00	3,817,248,300.00	7,060,100.00	99.81%
Орон нутгийн төсвөөс	222,750,000.00	222,750,000.00	0.00	100.00%
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	15,975,000.00	15,975,000.00	0.00	100.00%
Туслах үйл ажиллагааны орлого	210,000.00	-	210,000.00	
Урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх	336,137,800.00	-	336,137,800.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,399,381,200.00	4,055,973,300.00	343,407,900.00	92.19%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,399,381,200.00	4,358,598,552.57	40,782,647.43	99.0%
<u>Ажиллагчидтай холбогдсон зардал</u>	3,609,872,800.00	3,584,691,313.36	25,181,486.64	99.30%
<u>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</u>	3,207,886,500.00	3,188,898,933.93	18,987,566.07	99.40%
Цалин	2,123,429,400.00	2,037,867,149.00	85,562,251.00	95.97%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,084,457,100.00	1,151,031,784.93	-66,574,684.93	106.10%
<u>Нийгмийн хамгааллын шимтгэл</u>	401,986,300.00	395,792,379.43	6,193,920.57	98.45%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	337,668,500.00	333,364,601.77	4,303,898.23	98.72%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	64,317,800.00	62,427,777.66	1,890,022.34	97.06%
<u>Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал</u>	212,750,000.00	212,750,000.00	0.00	100.00%

Гэрэл цахилгааны зардал	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.00%
Түлш, халаалтын зардал	172,750,000.00	172,750,000.00	0.00	100.00%
Цэвэр, бохир усны зардал	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.00%
<u>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</u>	299,542,000.00	291,159,159.21	8,382,840.79	97.20%
Бусад бараа үйлчилгээний зардал	173,740,300.00	173,094,181.00	646,119.00	99.60%
Мэдээллийн технологийн зардал	77,423,700.00	69,686,978.21	7,736,721.79	90.00%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	22,403,000.00	22,403,000.00	0.00	100.00%
Урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.00%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,975,000.00	15,975,000.00	0.00	100.00%
<u>Урсгал шилжүүлэг</u>	277,216,400.00	269,998,080.00	7,218,320.00	97.39%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	261,198,500.00	253,980,180.00	7,218,320.00	97.23%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	16,017,900.00	16,017,900.00	0.00	100.00%
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u>		336,255,824.35	-336,255,824.35	
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>		33,630,571.78	-33,630,571.78	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар ажилтнуудын цалинг илүү тооцож олгосонтой холбоотой 665.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад залруулсан болно.

Үүнд:

- ✓ Нэр бүхий ажилтнуудад 665.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон зөрчлийг аудитын хугацаанд орон нутгийн төсвийн дансанд төлж барагдуулсныг залруулгаар бүртгэлээ.

Аудитаар нийт 656,866.9 мянган мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,411.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 653,455.1 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

1. Сургуулийн захирал, нярав 2,817.8 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, гэж заасныг тус тус зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой” байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2. Төсвийн 594.0 төгрөгийг тэмцээн уралдааны эрхийн төлбөрт зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.8-т “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно”, гэж заасныг тус тус зөрчсөн “нийцсэн бөгөөд зохистой” байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Тус сургуулийн дотоод хяналтын нэгж нь төлөвлөсөн 12 ажлаас 4 ажлыг бүрэн хэрэгжүүлсэн, алдаа зөрчлийг нэгтгэн дүгнээгүй, зөвлөмж хүргүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7.3, 3.7.8 зэрэг заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын нэгжид төлөвлөсөн хяналт шалгалтыг бүрэн хийх, хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх үүргүүдийг өгч биелэлтийг тооцох;

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

2.Илрүүлэлт:

Байгууллагад 2025 оны 10 дугаар сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй, ажлаас чөлөөлсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээг байгуулаагүй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д “Мэдээлэл хариуцагч ажлын байрны сул орон тооны талаарх Мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.” гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

Байгууллагад гарсан ажлын байрны сул орон тооны мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд зарлах, ажлаас чөлөөгдсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээ байгуулан, цалин хөлсийг олгох;

3.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 222,750.0 мянган төгрөгөөр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 173,632.8 мянган төгрөгөөр, аудитын тайлан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 257,072.3 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,1,6.1.6, 6.4.5, 6.4.9-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 6. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нэр бүхий ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон.	1	665.6			1	665.6	1	665.6				
Дүн	1	665.6			1	665.6	1	665.6				

Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэр бүхий 3 ажилтанд 4 цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон	1	2,817.8	1	2,817.8				
Дүн	1	2,817.8	1	2,817.8				

Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	
				Тоо	Дүн

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан төсвөөс уралдаан тэмцээний эрхийн төлбөрийг санхүүжүүлсэн	1	594.0	1	594.0				
2025 оны 10 дугаар сард гарсан 1 сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй	1						1	
Байгууллагын дотоод хяналтын нэгж үр дүнтэй ажиллаагүй	1						1	
Шилэн дансанд мэдээллийн мөнгөн дүнг үнэн зөв байршуулаагүй	1	653,455.1					1	653,455.1
Дүн	4	654,049.1	1	594.0			3	653,455.1